



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 12 сарын 22 өдөр

Дугаар А/174

Шивээговь сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.3.3, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн “Сумын 2023 оны төсөвт нэмэлт өөрчлөлт оруулах тухай” 06 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Шивээговь суманд мал эмнэлгийн ажил үйлчилгээг гэрээт захиалгаар гүйцэтгэж буй “Хийморь Алтай” Мал эмнэлэг үржлийн нэгжийн 2023 онд хийж гүйцэтгэсэн ажил үйлчилгээний хөлсөнд 7,900,000 (долоон сая есөн зуун мянга) төгрөгийг зарцуулсугай.

2.Мал угаалгын ажил үйлчилгээнд зарцуулагдах 7,900,000 (долоон сая есөн зуун мянга) төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангийн “Малын тоо толгойн албан татвар”-аас санхүүгийн анхан шатны баримт бичгийн бүрдлийг хангаж зарцуулахыг нягтлан бодогч (Л.Цэнд-Аюуш)-д зөвшөөрсүгэй.

3.Дээрх ажлын тайлан мэдээг авч нэгтгэн ажиллахыг Мал аж ахуйн үйлдвэрлэлийн төлөвлөлт, менежмент, малын үржил бүртгэлийн асуудал хариуцсан мэргэжилтэн (П.Ганжаргал)-д үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Отгонжаргал)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ч.СУГАРМАА